



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/139

Мөрөн сум

Ахмадын асрамжийн байнгын
үйлчилгээнд хамруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэн Уламбаярын Пагма (РП75102507) нь төрөл садан нь харж хандах боломжгүй, ганц бие, байнгын асаргаанд байх шаардлагатай, хөдөлмөрийн чадвар алдалт 80 хувьтай иргэн тул Ахмад настны асрамж үйлчилгээний төвд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн байнгын асрамжийн үйлчилгээнд хамруулахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Т.Октябрьбаяр)-д зөвшөөрсүгэй.

2.Тухайн иргэнийг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулахыг Цагаан-Уул сумын Засаг дарга (С.Гончигням)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ